



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2025/071/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Даланзадгад хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор: Т.Будсүрэн
Утас: 70533552 Цахим хаяг: Budsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2-3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4-11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11-12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12-13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13-14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	14-15
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	15-16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16-17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18-19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20-22

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ:



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25

№

129

танай

-ны №

-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 568,808.1 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, он дамжсан өвсний 110,100.5 мянган төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2,507,563.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл бусх

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны төсвийн санхүүжилт 1,397,684.0 мянган төгрөг болж өмнөх оноос 448,488.5 мянган төгрөг буюу 47.3 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 91.2 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.ӨСӨХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>720.953.990.54</u>	<u>632.634.485.09</u>
33	АВЛАГА	59,466,566.96	59,466,566.96
3352	Хувь хүмүүсээс авах авлага	59,466,566.96	59,466,566.96
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>661,487,423.58</u>	<u>573,167,918.13</u>
351	Түүхий эд материал	3,500,000.00	43,965,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,500,000.00	43,965,000.00
354	Хангамжийн материал	611,567,423.58	482,782,918.13
35410	Бичиг хэргийн материал	8,503,620.00	7,004,820
35420	Аж ахуйн материал	74,079,020.00	55,670,090
35430	Сэлбэг хэрэгсэл	23,487,434.00	49,499,90
35470	Бусад хангамжийн материал	505,497,349.58	420,058,508.23
35600	Мал амьтад	46,420,000.00	46,420,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,372,406,954.03</u>	<u>68,916,465,928.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	71,372,406,954.03	68,832,427,928.55
392	Биет хөрөнгө	71,288,111,454.10	68,832,427,928.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,343,840,096.39	7,204,834,784.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	-892,702,956.29	-1,276,981,961.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл	397,283,644.00	397,283,644.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-215,709,827.80	-264,284,366.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	747,964,178.50	837,384,937.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-321,969,669.01	-441,019,979.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	576,785,481.00	593,745,481.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-262,319,726.00	-316,092,241.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	191,897,200.00	191,897,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,185,200.28	-54,564,640.32
39209	Зам, Гүүрийн байгууламж	70,505,661,984.02	70,786,658,404.02
39210	Хуримтлагдсан элэгдэл	-4,766,433,750.43	-8,826,433,333.53
393	Биет бус хөрөнгө	<u>84,295,499.93</u>	<u>84,038,000.00</u>
39301	Программ хангамж	3,132,500.00	3,132,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,875,000.07	-3,132,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	84,038,000.00	84,038,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>72,093,360,944.57</u>	<u>69,549,100,413.64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>112,920,469.37</u>	<u>96,175,900.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	112,920,469.37	96,175,900.00
413	Өглөг	112,920,469.37	96,175,900.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,819,969.37	-
41361	Байгууллагад төлөх өглөг	110,100,500.00	96,175,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>71,980,440,475.20</u>	<u>69,452,924,513.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>71,980,440,475.20</u>	<u>69,452,924,513.64</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	844,020,134.69	844,020,134.69
512	Хуримтлагдсан үр дүн	70,897,263,826.20	68,369,747,864.64
51210	Өмнөх үеийн үр дүн	70,897,263,826.20	70,698,704,117.94
51220	Тайлант үеийн үр дүн		-2,328,956,253.30

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,156,514.31	239,156,514.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>72,093,360,944.57</u>	<u>69,549,100,413.64</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,731,238,570.08	4,048,865,711.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,531,636,057.08	2,546,300,473.87
120	Нийтлэг татварын бус орлого	3,531,636,057.08	2,546,300,473.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,658,000.00	22,487,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,658,000.00	22,487,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,213,300,090.50	2,248,371,867.22
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	291,677,966.58	275,440,906.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,199,602,513.00	1,502,565,238.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	598,300,300.00	915,683,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	598,300,300.00	915,683,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	345,164,498.00	186,543,838.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	341,289,030.00	149,021,906.95
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,385,468.00	37,521,931.05
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,473,713,969.74	6,357,971,965.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,473,713,969.74	6,292,629,865.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,155,436,789.86	6,035,923,756.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,856,823.04	601,667,275.20
210101	Үндсэн цалин	228,742,111.57	214,173,856.51
210102	Нэмэгдэл	70,114,711.47	265,985,412.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,532,000.00
210104	Урамшуулал	-	90,402,388.51
210105	Гэрээт ажлын хөлс	-	9,573,618.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,501,689.87	73,254,927.78
210201	Тэтгэврийн даатгал	26,066,569.38	53,761,078.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,922,186.94	4,945,177.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,869.74	2,641,230.14
210204	Ажилгүйдлийн даатгал	541,816.04	2,501,923.67
210205	Эрүүл мэндийн даатгал	5,546,247.77	9,405,518.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,447,767.60	94,571,973.11
210301	Гэрэл, цахилгаан	6,942,353.80	6,803,101.31
210302	Түлш, халаалт	62,133,013.80	82,778,671.80
210303	Цэвэр, бохир ус	5,372,400.00	4,990,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,057,298.00	77,503,883.00
210401	Бичиг хэрэг	391,500.00	6,145,400.00
210402	Тээвэр, шатахуун	46,551,798.00	60,208,683.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,172,000.00	5,277,000.00

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,600,000.00	3,788,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,342,000.00	2,084,200.00
2105	Нормативт зардал	513,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	728,350.00	77,666,384.10
210601	Багаж техник хэрэгсэл	-	26,144,534.10
210604	Урсгал засвар	728,350.00	51,521,850.00
2107	Томилолт, зочны зардал	12,782,000.00	19,360,000.00
210702	Дотоод албан томилолт	12,782,000.00	19,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	134,428,394.00	516,823,129.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	134,428,394.00	516,823,129.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,538,121,467.35	4,575,076,184.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	183,821,950.00	62,018,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,305,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,354,299,517.35	4,505,753,184.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	318,277,179.88	256,706,108.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,866,308.00	49,690,483.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	7,180,750.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,146,688.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,866,308.00	35,363,045.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	245,410,871.88	207,015,625.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,470,405.60	206,491,240.59
213405	Нэмэлт санхүүжилт Төвлөрүүлэх шилжүүлэг	47,940,466.28	524,384.95
	Хөрөнгийн зардал		65,342,100.00
223001	Бусад хөрөнгө		65,342,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,257,524,600.34</u>	<u>-2,309,106,253.30</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	19,850,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	19,850,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(28,316,770.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,257,524,600.34</u>	<u>-2,328,956,253.30</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,226,260,513.00	1,525,052,938.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,658,000.00	22,487,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,658,000.00	22,487,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,658,000.00	22,487,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,658,000.00	22,487,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,199,602,513.00	1,502,565,238.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	345,164,498.00	186,543,838.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	341,289,030.00	149,021,906.95
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,385,468.00	37,521,931.05
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	854,438,015.00	1,316,021,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт, орон нутгийн төсөвт байгууллага	854,438,015.00	1,316,021,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,171,760,513.00	1,359,191,628.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,171,760,513.00	1,359,191,628.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	853,483,333.12	1,107,960,919.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,487,509.65	604,487,244.57
210101	Үндсэн цалин	225,372,798.18	216,993,825.88
210102	Нэмэгдэл	70,114,711.47	265,985,412.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,532,000.00
210104	Урамшуулал		90,402,388.51
210105	Гэрээт ажлын хөлс		9,573,618.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,501,689.87	73,254,927.78
210201	Тэтгэврийн даатгал	26,066,569.38	53,761,078.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,922,186.94	4,945,177.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,869.74	2,630,342.14
210204	Ажилгүйдлийн даатгал	541,816.04	2,512,811.67
210205	Эрүүл мэндийн даатгал	5,546,247.77	9,405,518.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,447,767.60	94,571,973.11
210301	Гэрэл, цахилгаан	6,942,353.80	6,803,101.31
210302	Түлш, халаалт	62,133,013.80	82,778,671.80
210303	Цэвэр, бохир ус	5,372,400.00	4,990,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,189,618.00	75,215,083.00
210401	Бичиг хэрэг	6,859,700.00	4,646,600.00
210402	Тээвэр, шатахуун	46,551,798.00	59,418,683.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,172,000.00	5,277,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,600,000.00	3,788,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,006,120.00	2,084,200.00
2105	Нормативт зардал	778,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,069,984.00	54,826,850.00
210604	Урсгал засвар	26,069,984.00	54,826,850.00
2107	Томилолт, зочны зардал	12,782,000.00	19,360,000.00
210702	Дотоод албан томилолт	12,782,000.00	19,360,000.00

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,154,244.00	117,873,491.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,154,244.00	117,873,491.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,071,720.00	68,371,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	191,656,220.00	61,006,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	415,500.00	7,364,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	318,277,179.88	251,230,708.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,866,308.00	49,690,483.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	7,180,750.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,146,688.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,866,308.00	35,363,045.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	245,410,871.88	201,540,225.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,470,405.60	201,015,840.59
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	47,940,466.28	524,384.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	54,500,000.00	165,861,310.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,500,000.00	165,861,310.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	54,500,000.00	165,861,310.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,000,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-54,500,000.00	-165,861,310.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	844,020,134,69	239,156,514,31	69,639,739,225,86	70,722,915,874,86
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	844,020,134,69	239,156,514,31	69,639,739,225,86	70,722,915,874,86
3	Тайлант үеийн үр дүн	-	-	1,257,524,600,34	1,257,524,600,34
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	844,020,134,69	239,156,514,31	70,897,263,826.20	71,980,440,475.20
5	НББ-ын бодлогын өөрчлөлт			-198,559,708.26	-198,559,708.26
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	844,020,134,69	239,156,514,31	70,897,263,826.20	71,980,440,475.20
7	Тайлант үеийн үр дүн			-2,328,956,253.30	-2,328,956,253.30
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	844,020,134,69	239,156,514,31	68,369,747,864.64	69,452,924,513.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,541,482,300.00	1,137,493,259.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,326,482,300.00	1,061,631,949.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,286,665,000.00	993,395,261.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	633,646,700.00	553,021,305.49
210101	Үндсэн цалин	266,251,100.00	213,984,825.88
210102	Нэмэгдэл	294,946,500.00	265,985,412.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,860,000.00	21,532,000.00
210104	Урамшуулал	28,121,900.00	41,945,449.43
210105	Гэрээт ажлын хөлс	17,467,200.00	9,573,618.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,326,800.00	67,429,649.81
210201	Тэтгэврийн даатгал	96,981,000.00	49,881,726.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,301,300.00	4,471,300.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,685,800.00	2,333,625.46
210204	Ажилгүйдлийн даатгал	3,685,800.00	2,121,530.93
210205	Эрүүл мэндийн даатгал	12,672,900.00	8,621,466.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,928,200.00	94,571,973.11
210301	Гэрэл, цахилгаан	13,999,100.00	6,803,101.31
210302	Түлш, халаалт	80,866,600.00	82,778,671.80
210303	Цэвэр, бохир ус	7,062,500.00	4,990,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,417,100.00	71,939,142.00
210401	Бичиг хэрэг	6,758,900.00	4,646,600.00
210402	Тээвэр, шатахуун	56,166,400.00	56,142,742.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,030,100.00	5,277,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,900,000.00	3,788,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,561,700.00	2,084,200.00
2105	Нормативт зардал	1,230,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,230,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,045,600.00	34,186,850.00
210604	Урсгал засвар	50,045,600.00	34,186,850.00
2107	Томилолт, зочны зардал	20,530,000.00	18,850,000.00
210702	Дотоод албан томилолт	20,530,000.00	18,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	158,473,100.00	117,873,491.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,473,100.00	117,873,491.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,067,500.00	35,522,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,500,000.00	28,158,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,817,300.00	23,236,688.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,817,300.00	23,236,688.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,000.00	-

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,632,000.00	7,146,688.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,785,300.00	16,090,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,543,838.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	141,543,838.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,565,658.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,465,939.08
210101	Үндсэн цалин	3,009,000.00
210104	Урамшуулал	48,456,939.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,825,277.97
210201	Тэтгэврийн даатгал	3,879,352.30
210202	Тэтгэмжийн даатгал	473,876.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	296,716.68
210204	Ажилгүйдлийн даатгал	391,280.74
210205	Эрүүл мэндийн даатгал	784,051.84
2104	Хангамж, бараа материалын зардал	3,275,941.00
210402	Тээвэр, шатахуун	3,275,941.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,640,000.00
210604	Урсгал засвар	20,640,000.00
2107	Томилолт, зочны зардал	510,000.00
210702	Дотоод албан томилолт	510,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,848,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,848,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,978,179.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,453,795.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,273,045.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	524,384.95
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	524,384.95
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	186,543,838.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	186,543,838.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,021,906.95
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,521,931.05

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал болон эд хогшил, урсгал засварын зардлыг хэмнэх зэрэг холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр нийт 500.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 500.0 мянган төгрөгийн 1 зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж ажилласан байна. Үүнд:

- ❖ **Илрүүлэлт:1** Нэмэлт санхүүжилтийн данснаас баруун бүсийн төрийн албан хаагчдын уулзалт, зөвлөгөөнд /210901/ зардлаас 500,000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс авсан байна.
- ❖ Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-д "хэвлэлийн захиалгын төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-д заасантай нийцэхгүй байна.
- ❖ **Өгсөн албан шаардлага-1:** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,873,786.2 мянган төгрөгийн алдаа⁵ илэрснээс аудитын явцад 1,873,786.2 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- ✓ Санхүү байдлын тайлангийн Тайлант үеийн үр дүнг, Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүнтэй тулган баталгаажуулахад 221,512,584.95 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогын дүнг, Бараа материалын тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан дүнтэй тулган баталгаажуулахад 42,381,906.65 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,405,969.37 төгрөгөөр дутуу, Бичиг хэргийн зардлыг 5,087,750.00 төгрөгөөр илүү, Тээвэр, шатахууны зардлыг 12,337,845 төгрөгөөр илүү, Шуудан холбоо, интернэтийн төлбөрийн зардлыг 507,000 төгрөгөөр илүү, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгалын зардлыг 2,428,600 төгрөгөөр дутуу, Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлыг 1,584,200 төгрөгөөр дутуу, Аж ахуйн материал худалдан авах зардлыг 5,199,700 төгрөгөөр илүү, Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 19,850,000 төгрөгөөр илүү, Эд хогшил, урсгал засварын зардлыг 22,894,534.10 төгрөгөөр илүү, Томилолт, зочны зардлыг 680,000 төгрөгөөр илүү, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 413,133,928 төгрөгөөр илүү, Бараа үйлчилгээний бусад зардлыг 27,708,150 төгрөгөөр дутуу, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 6,643,000 төгрөгөөр дутуу тус тус илэрхийлсэн байна.
- ✓ Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 428,090.15 төгрөг, Шуудан холбооны өглөгийг 507,000 төгрөг, Тээвэр шатахууны өглөгийг 11,043,560 төгрөг, Албан томилолтын өглөгийг 16,004,000 төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан байна
- ✓ Байгууллагын үндсэн хөрөнгийн барилга, байгууламжид бүртгэлтэй 1,020,689,951 төгрөгийн балансын үнэтэй Конторын 3 давхар барилга, 41,835,519 төгрөгийн балансын үнэтэй Баян конторын ашиглалтын хугацааг 1 жилээр, 89,251,019 төгрөгийн балансын үнэтэй Төхөм конторын ашиглалтын хугацааг 2 жил, 159,369,489.12 төгрөгийн балансын үнэтэй сумын конторыг 10 жилээр тус тус бүртгэж үлдэх өртөггүй тайлагнасан байна.

Аудитаар нийт 281,457.1 мянган төгрөгийн зөрчил⁹ илэрснээс 27,950.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлж, 251,159.4 мянган төгрөгийн 6 зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага, 2,347.1 мянган төлбөрийн 1 зөрчилд акт тогтоож ажилласан байна.

5.1 **ТӨЛБӨРИЙН АКТ:** Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

- ❖ **Илрүүлэлт:1** Нягтлан бодогчид 1,183,730 төгрөг, Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчид 1,163,327 төгрөгийг ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй үндэслэлээр ээлжийн амралтын олговортой давхардуулан урамшуулал олгосон байна.
- ❖ Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.
- ❖ **Өгсөн төлбөрийн акт-1:** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу төлбөрийн акт тогтоох

5.2 **АЛБАН ШААРДЛАГА:** Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- ❖ **Илрүүлэлт:1** Хагас, бүтэн жилээр эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг НХ-Маягт БМ-8 маягт хөтлөөгүй, 70,511,878,464.24 төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байгаа нь төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналт алдагдсан байх эрсдэлийг үүсгэсэн байна
- ❖ Энэ нь УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллого заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.
- ❖ **Өгсөн албан шаардлага:1** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 "Хууль тогтоож, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасны дагуу албан шаардлага хүргүүлэх
- ❖ **Илрүүлэлт:2** Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4,799,800 төгрөгийн балансын үнэтэй нөөтбүүк, 4942-ӨМҮ улсын дугаартай 29,736,434 төгрөгийн балансын үнэтэй Пургон, 2794-ӨМҮ улсын дугаартай 34,500,000 төгрөгийн балансын үнэтэй Пургон машин байгууллага дээр биетээр байхгүй байна.
- ❖ Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4 /үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ"-д заасныг хэрэгжүүлээгүй байна.
- ❖ **Өгсөн албан шаардлага:2** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх.
- ❖ **Илрүүлэлт:3** Бараа материалын тайланг НХМаягт БМ-9 маягтаар хөтлөөгүй, 568,808,133.13 төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй байгаа нь эргэлтийн хөрөнгө дутагдах эрсдэлийг үүсгэсэн байна..
- ❖ Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэцэглэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх", 72 дугаар зүйлийн 72.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 8-д /... хөрөнгийн тооллогын бүртгэлд байгууллагын нэр, эд

хөрөнгийн нэр төрөл, хаана ашиглагдаж байгаа, хөрөнгийн чанар байдал зэргийг тэмдэглэхийн хамт тооллогын бүртгэлийн хуудас бүрийн ард тооллогын комиссын дарга, гишүүд, эд хариуцагч гарын үсэг зурна/-д заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- ❖ **Өгсөн албан шаардлага:3** Эргэлтийн хөрөнгийн тооллогыг тухай бүр холбогдох журмын дагуу чанартай гүйцэтгэж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг арилгаж ажиллах албан шаардлага хүргүүлэх
- ❖ **Илрүүлэлт:4** Он дамжсан 110,100,500 төгрөгийн өвсний өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, мөн барагдуулж ажиллаагүй байна
- ❖ Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" дахь заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.
- ❖ **Өгсөн албан шаардлага:4** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх
- ❖ **Илрүүлэлт:5** Шатахууны зарцуулалтыг түүвэрлэн жолоочийн тооцооны хуудас байхгүй, спидометрийн заалт бичээгүй, шаардах хуудас бөглөөгүй, шатахууны норм, норматив тооцоогүй, шатахууныг хяналтгүй зарцуулсан байна.
- ❖ Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.21-д "нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын тамгын газар", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралт, 2 дугаар хавсралт, 3 дугаар хавсралт-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- ❖ **Өгсөн албан шаардлага:5** Анхан шатны баримтыг бүрдүүлж, жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв хөтөлж, шатахууны тооцоо бодох, түлш шатахууныг нормоор зарцуулах зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх
- ❖ **Илрүүлэлт:6** Нэмэлт санхүүжилтийн данснаас баруун бүсийн төрийн албан хаагчдын уулзалт, зөвлөгөөнд /210901/ зардлаас 500,000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс авсан байна.
- ❖ Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-д "хэвлэлийн захиалгын төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- ❖ **Өгсөн албан шаардлага:6** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

5.3 ЗӨВЛӨМЖ: Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- ❖ **Илрүүлэлт:1** Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 140 нэр төрлийн 587,156,574.50 төгрөгийн үндсэн хөрөнгөд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байгаа.
- ❖ Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох

эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ"-д заасантай нийцэхгүй байна.

- ❖ **Өгсөн зөвлөмж-1:** Эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгах, сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн эрх бүхий газарт хүргүүлэн шийдвэрлэж ажиллах зөвлөмж хүргүүлэх
- ❖ **Илрүүлэлт-2:** Мэргэжлийн байгууллагаар эвдрэл, гэмтлийг тодорхойлсон дүгнэлт гаргуулаагүй 27,950,600 төгрөгөөр 3 автомашинд урсгал засварын зардал гаргасан, техник ашиглалтын паспорт хөтлөөгүй, төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллаагүй байна.
- ❖ Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1"Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 2."Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна"-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- ❖ **Өгсөн зөвлөмж-1:** Төрийн өмчийн ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, техник ашиглалтын паспортыг бүрэн хөтөлж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүү байдлын тайлангийн Тайлант үеийн үр дүнг, Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүнтэй тулган баталгаажуулахад 221,512,584.95 төгрөгөөр зөрүүтэй тусгасан	1	221,512.5			1	221,512.5	1	221,512.5				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогын дүнг, Бараа материалын тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан дүнтэй тулган баталгаажуулахад 42,381,906.65 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.	1	42,381.9			1	42,381.9	1	42,381.9				
Санхүүгийн үр дүнгийн тайланд Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,405,969.37 төгрөгөөр дутуу, Бичиг хэргийн зардлыг 5,087,750.00 төгрөгөөр илүү, Тээвэр, шатахууны зардлыг 12,337,845 төгрөгөөр илүү, Шуудан холбоо, интернэтийн төлбөрийн зардлыг 507,000 төгрөгөөр илүү, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгалын зардлыг 2,428,600 төгрөгөөр дутуу, Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлыг 1,584,200 төгрөгөөр дутуу, Аж ахуйн материал худалдан авах зардлыг 5,199,700 төгрөгөөр илүү, Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 19,850,000 төгрөгөөр илүү, Эд хогшил, урсгал засварын зардлыг 22,894,534.10 төгрөгөөр илүү, Томилолт, зочны зардлыг 680,000 төгрөгөөр илүү, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 413,133,928 төгрөгөөр илүү, Бараа үйлчилгээний бусад зардлыг 27,708,150 төгрөгөөр дутуу, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 6,643,000 төгрөгөөр дутуу тус илэрхийлсэн байна.	1	520,460.6			1	520,460.6	1	520,460.6				
Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 428,090.15 төгрөг, Шуудан холбооны өглөгийг 507,000 төгрөг, Тээвэр шатахууны өглөгийг 11,043,560	1	27,982.6			1	27,982.6	1	27,982.6				

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

төгрөг, Албан томилолтын өглөгийг 16,004,000 төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан байна												
Байгууллагын үндсэн хөрөнгийн барилга, байгууламжид бүртгэлтэй 1,020,689,951 төгрөгийн балансын үнэтэй Конторын 3 давхар барилга, 41,835,519 төгрөгийн балансын үнэтэй Баян конторын ашиглалтын хугацааг 1 жилээр, 89,251,019 төгрөгийн балансын үнэтэй Төхөм конторын ашиглалтын хугацааг 2 жил, 159,369,489.12 төгрөгийн балансын үнэтэй сумын конторыг 10 жилээр тус тус бүртгэж үлдэх өртөггүй тайлагнасан байна.	1	1,061,448.4			1	1,061,448.4	1	1,061,448.4				
Дүн	5	1,873,786.2			5	1,873,786.2	5	1,873,786.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А/т/тоо	Тоо	Дүн
Нягтлан бодогчид 1,183,730 төгрөг, Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчид 1,163,327 төгрөгийг ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй үндэслэлээр ээлжийн амралтын олговортой давхардуулан урамшуулал олгосон байна.	1	2,347.1	1	2,347.1								
Хагас, бүтэн жилээр эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг НХ-Маягт БМ-8 маягт хөтлөөгүй, 70,511,878,464.24 төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байгаа нь төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналт алдагдсан байх эрсдэлийг үүсгэсэн байна	1	0			1	0						
Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 140 нэр төрлийн 587,156,574.50 төгрөгийн үндсэн хөрөнгөд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	0					1	0				
Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4,799,800 төгрөгийн балансын үнэтэй нээтбүүк, 4942-ӨМҮ улсын дугаартай 29,736,434 төгрөгийн балансын үнэтэй Пургон, 2794-ӨМҮ улсын дугаартай 34,500,000 төгрөгийн балансын үнэтэй Пургон машин байгууллага дээр биетээр байхгүй байна	1	69,036.2			1	69,036.2						
Бараа материалын тайланг НХМаягт БМ-9 маягтаар хөтлөөгүй, 568,808,133.13 төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй байгаа нь эргэлтийн хөрөнгө дутагдах эрсдлийг үүсгэсэн байна	1	0			1	0						
Он дамжсан 110,100,500 төгрөгийн өвсний өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, мөн барагдуулж ажиллаагүй байна	1	110,100.5			1	110,100.5						
Шатахууны зарцуулалтыг түүвэрлэн жолоочийн тооцооны хуудас байхгүй, спидометрийн заалт бичээгүй, шаардах хуудас бөглөөгүй, шатахууны норм, норматив тооцоогүй, шатахууныг хяналтгүй зарцуулсан байна.	1	71,522.7			1	71,522.7						

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мэргэжлийн байгууллагаар эвдрэл, гэмтлийг тодорхойлсон дүгнэлт гаргуулаагүй 27,950,600 төгрөгөөр 3 автомашинд урсгал засварын зардал гаргасан, техник ашиглалтын паспорт хөтлөөгүй, төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллаагүй байна.	1	27,950.0					1	27,950.0				
Нэмэлт санхүүжилтийн данснаас баруун бүсийн төрийн албан хаагчдын уулзалт, зөвлөгөөнд /210901/ зардлаас 500,000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс авсан байна.	1	500.0			1	500.0						
ДҮН	9	281,457.1	1	2,347.1	6	251,159.4	2	27,950.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуультай холбоотой зөрчил гараагүй байна.								
Дүн								
Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил								
Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил гараагүй байна.								
Дүн								